

# "ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20.11. оны 01. сарын 18. өдөр

Дугаар №.....01

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-д нэмэлт өөрчлөлт оруулсан Засгийн газрын 2018 оны 335 дугаар тогтоолын 2.9<sup>1</sup> дэх хэсэг, "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.11.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хавсралт ёсоор баталсугай.
2. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлж, дүрмийг мөрдөж ажиллахыг гүйцэтгэх захирал /Л.Эрхбаатар/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Б.Ерэн-Өлзий/-д даалгасугай.

Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн  
төлөөлөгч


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ  
төлөөлж:



Б.НАСАНТОГОХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ  
төлөөлж:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



“Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийн хувьцаа зээмшиждэйн  
хурлын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн  
Ус тогтоолын хавсралт

**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААН ЦАХИЛГААН СТАНЦ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ**

**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү дүрэм нь “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүрийг тодорхойлсон эрх зүйн үндсэн бичиг баримт мөн.

1.2. “Эрдэнэтийн Дулааны Цахилгааны Станц” төрийн өмчит хувьцаат компани /цаашид “компани гэх/ нь Монгол улсын иргэний хууль, Компанийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.4. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн өмчлөгч нь төр байх бөгөөд хувьцаа зээмшигч нь Засгийн газраас эрх олгосон төрийн байгууллага байна.

1.5. Компани нь дүрэмд заасан зорилтоо хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанаас гадна, хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг өөрийн төлөөлөгчийн газар, охин компаниудаараа дамжуулан гүйцэтгэж болно. Компанийн төлөөллийн газрыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр байгуулна.


1.6. Компанийн хувьцаа зээмшигчийн эрхийг 70 хувийг Эрчим хүчиний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа зээмшигчийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

1.7. Компанийн оноосон нэр нь “Эрдэнэтийн Дулааны Цахилгааны Станц” төрийн өмчит хувьцаат компани, товчилсон нэр нь “ЭДЦС” ТӨХК болно.

1.8. Компанийн байршил нь Орхон аймаг, Баян-Өндөр сум Баян-Цагаан багийн нутагт байрлана. Хаягийн өөрчлөлтийг компанийн гүйцэтгэх удирдлага тухай бүр гэрчилгээнд тусгуулна. Утас: 70350951, Факс: 70353718, E-mail: info2erdenetpp.energy.mn болно.

1.9. Компани нь өөрийн барцааны тэмдэг болон бэлгэдэл /эмблем/-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэж болно.



1.10. Бэлгэдэл, барааны тэмдэгийн загварыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн Компани эдэлнэ.

1.11. Тэмдэгийг компанийн гүйцэтгэх удирдлагаас итгэмжлэн хариуцсан этгээд хадгална.

**ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ, ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЯВУУЛАХ ХУГАЦАА**

2.1. Компанийн үндсэн зорилт нь хэрэглэгчийг дулаан, цахилгааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино.

2.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь цахилгаан үйлдвэрлэх, дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, эрчим хүчин тоног төхөөрөмж, даралтат сав шугам хоолойг ашиглах, засвар үйлчигээ хийх, түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагааг эрхэлж болно.

2.3. Компани нь хуулиар хориглоогүй бөгөөд орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргана.

2.4. Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах, Үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

2.5. Компанийн дүрмэнд орсон. Өөрчлөлтүүд хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

2.6. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, хувьчлах,

татан буулгахаар шийвэрлэсэнээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

2.7. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, үйл ажиллагаа Иргэний хууль% компаний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдана.



**ГУРАВ. КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ,  
ХУВЬЦАА**

3.1. Компанийн өөрийн хөрөнгө хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 50 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 388.949.134 ширхэг энгийн хувьцаатай байна.

3.2. Компани нь хувьцаа гаргаж болох бөгөөд гаргах хувьцааны төрөл, тоо, нэрлэсэн үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс санал болгосноор Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно.

3.3. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бусад үнэт цаас гаргаж болно.

3.4. Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эмхүл хувьцаа нэмж гаргах замаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж болно.

3.5. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд, хөрөнгийг тусгайллан өмчлөх эрхийг нотлохгүй.

3.6. Компанийн хөрөнгө нь 100 хувь төрийн өмчид байгааг харгалzan компанийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гарах хүртэл арижаалагдах эрхгүй хувьцаа байна.

**ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ**

4.1. Ногдол ашиг хувиарлах тухай шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргана.


4.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хувиарлах эсэх талаар шийдвэр гаргана. Хэрэв ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэр гарсан бол энэ тухайгаа Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнах үүрэгтэй.

4.3. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энэ тухай шийдвэрт хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

4.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилсан бол түүний тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хурал болон Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнана.

4.5. Компанийн эргүүлэн авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

4.6. Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.



## ТАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА.

5.1. Компанийн удирдлага нь дараах бүтэцтэй байна.

5.1.1 Хувьцаа эзэмшигчдийн Хурал

5.1.2 Төлөөлөн Удирдах Зөвлөл

5.1.3 Гүйцэтгэх удирдлага

## ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

6.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит, ээлжит бус байна.

6.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн (4) сарын дотор зарлан хуралдуулна.

6.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг Эрчим хүчний яамнаас баталсан удирдамжийн дагуу хэлэлцэнэ.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

6.4.Шаардлагатай гэж үзвэл Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компаний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий этгээд зарлан хуралдуулж болно.

6.5. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана.

6.5.1 хурал хуралдуулах газар, өдөр, цаг,

6.5.2 хурлын хэлэлцэх асуудал

6.5.3 хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр

6.5.4 хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам,

6.5.5 хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт,


6.5.6 саналын хуудсаар санал авах бол тухайн саналын хуудасны агуулга,

6.5.7 саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр,

6.5.8 хурлын дарга,

6.5.9 тооллогын комиссын дарга, гишүүд.

6.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.



6.7. Компани энэ хуулийн 60.1-д заасан шийдвэр гарснаас хойш тав хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргэх үүрэгтэй

6.8. Хурлын зard дараах зүйлсийг тусгана.

6.8.1 Компанийн оноосон нэр;

6.8.2 хурал хийх өдөр, цаг, газар

6.8.3 Бүртгэлийн өдөр

6.8.4 Хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам

6.9. Ээлжит хурал хуралдуулах үед хувьцаа эзэмшигчид дараах мэдээллийг танилцуулна.

6.9.1. компанийн санхүүгийн жилийн тайлан;

6.9.2. санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт

6.9.3.. тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэлүүд

6.9.4. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга

6.9.5. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;

6.9.6. компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал;

6.9.7. бизнесийн үйл ажиллагааны тайлан;


6.10. Ээлжит бус хурлыг дараах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл хуралдуулна.

6.10.1. төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

6.10.2. төлөөлөн удирдах зөвлөлийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;

6.10.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;

6.10.4. компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;



6.10.5.төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;

6.10.6.аудитын хорооноос эзлжит бус хурал хийхийг шаардсан;

6.11. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.

6.11.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

6.11.2.нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

6.11.3 компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

6.11.4.компанийн хэлбэрийг өөрчлөх;

6.11.5.компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

6.11.6.хувьцааг хуваах буюу нэгтгэх;

6.11.7 компанийн зорилтод түвшинг батлах

6.11.8.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх, тэдний цалин, урамшуулалын хэмжээг тогтоох,, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

6.11.9 компаний гүйцэтгэх удирдлагыг томилох, бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх асуудлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд удирдамж өгөх

6.11.10 хувьцаа эзэмшигчид нь хувьцаа, бусад үнэт цаасыг хууль тогтоомжид заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрх өдлэх эсэх


6.11.11 компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

6.11.12.компаний тухай хуулийн 11-р бүлэгт заасан их хэмээний хэлцэлийг батлах

6.11.13 мөн хуулийн 11-р зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах

6.11.14 компаний тухай хууль болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулахаар шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд

6.12.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг Компаний тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгоно.



6.13. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, хурлын тэмдэглэл гаргана. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөнө.

### ДОЛОО ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

7.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

7.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 5 нь Эрчим хүчний яамны гишүүн байна.

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

7.2.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.2.2.компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тогтоох;

7.2.3.хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан зорилтод түвшинг үндэслэн компанийн бизнес төлөвлөгөөг батлах;

7.2.4 компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах:

7.2.5 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах:

7.2.6.компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;

7.2.7.компанийн энгийн хувьцаа болон бусад үнэт цаас гаргах;


7.2.8.компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

7.2.9 компанийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах шийдвэр гаргах

7.2.10.компанийн гүйцэтгэх удирдлагыг Эрчим хүчний сайдын удирдамжаар томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

7.2.11.компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал, урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах.



7.2.12. компанийн гүйцэтгэх захирал, орлогч захирал, санхүү эрхэлсэн дэд захирал, үйлдвэрлэл эрхэлсэн орлогч захирал (ерөнхий инженер), ерөнхий нягтлан бодогч нарыг томилох, бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.

7.2.13. компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах.

7.2.14. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах.

7.2.15. компаниас олгох ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох:

7.2.16. компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах.

7.2.17. компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргах.

7.2.18. компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах.

7.2.19. хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлуэл хийх зөвшөөрөл олгох.

7.2.20. хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарахгүй бусад асуудлыг шийдвэрлэх.


8.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал нийт гишүүдийн дийлэнх олонх нь оролцсноор хүчин төгөлдөр болно.

8.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

8.3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүнийг хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэр гаргах, хяналт тавих үүргийг хүлээнэ.

8.4. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан тогтоол нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

8.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.



8.6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно.

8.7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

8.8. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарах шийдвэрийн талаар хуралд оролцсон гишүүдийн санал тэнцвэл Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

8.9. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын эрх болон бусад холбогох асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

8.10. Хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангасан этгээд байна.

8.10.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5 дээш хувийг эзэмшдэггүй.

8.10.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй.


8.10.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй.

8.10.4. компанийтай төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад байдлаар бизнесийн аливаа холбоогүй.

8.11. хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй

8.11.1. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сэргээр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх:

8.11.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;



8.11.3.хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

8.11.4.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах талаар санал боловсруулах;

8.11.5 гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих.

8.12. Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Аудитын, Цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороог байгуулан ажиллуулна.

8.13. Хороодын гишүүдийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний 2/3нь хараат ус гишүүн байна.

8.14. Хороо нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулах үүрэгтэй.

8.15. Аудитийн хорооний дарга нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

8.15.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

8.15.2.дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах.

8.15.3.аудитын байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар айдитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/

8.15.4.их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

8.15.5.компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих:

8.15.6. компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс шилжүүлсэн болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

8.16. Нэр дэвшүүлэх хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ.

8.16.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

8.16.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэхүү дүрмийн 7.12-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

8.16.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

8.16.4. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

8.16.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

8.16.6. Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.

8.17. Цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж.

Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулна.


8.17.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих;

8.17.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулалт олгох санал боловсруулах;

8.17.3. Компанид мөрдэж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

8.17.4. Комданийн төлөөлөн удирдах зөвлөлөөс шилжүүлсэн болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

8.19. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно. Төлөөлөн



удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэгийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

8.20. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд нэгээ доошгүй удаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнан.

#### НАЙМ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

8.1 Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна.

8.2. Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн удирдах зөвлөл томилоно.

/Энэ хэсэгт 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

8.3. Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээнд Төлөөлөн Удирдах зөвлөлийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

8.4. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах Зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.


8.5. Гүйцэтгэх захирлыг томилох, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

8.6. Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоо шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл хэдийд ч гаргаж болно.

8.7. Гүйцэтгэх захирал нь компанийн орлогч захирал, Санхүү эрхэлсэн орлогч захирал, үйлдвэрлэл эрхэлсэн орлогч захирал, (ерөнхий инженер), ерөнхий нягтлан бодогч, салбар, төлөөлөгчийн газрын захирлыг томилох, тэдгээрийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, яөлөөлөх асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд санал оруулж шийдвэрлүүлнэ. Шаардлагатай бол Төлөөлөн Удирдах Зөвлөл өөрийн санаачилгаар тэдгээрийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.

8.8. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна.

8.8.1 Менежментийн ур чадвартай, 5-аас доошгүй жил удирдах ажил гүйцэтгэж байсан мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан удирдлагын зохих дадлага



туршлагатай, эрчим хүчний инженер, эсхүл санхүү эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх:

8.8.2. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх:

8.8.3. Ял шийтгэлгүй байх:

8.8.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх:

8.9. Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий Захирлын зөвлөл ажиллана. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батлана.

8.10. Гүйцэтгэх захиралтай холбогдох үүссэн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдолд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцно.

8.11. Гүйцэтгэх захирал дор дурьдсан эрх, эдэлж үүрэг хүлээнэ.

8.11.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй Төлөөлөн Удирдах Зөвлөлийн удаа ажлын үр дүнг тайлагнан дүгнүүлэх:

8.11.2. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах:

8.11.3. Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтод түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловруулж, Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулан, батлуулах:

8.11.4. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах:

8.11.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах:

8.11.6. компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан Компанийг удирдах:

8.11.7. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх:

8.11.8. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх:

8.11.9. компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцээлан шийдвэрлүүлэх:

8.11.10. компанийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох асуудлаар тушаалаар гаргаж биелэлтийг хангуулах:

8.11.11. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах:

8.11.12. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зөвшөөрлийн үндсэн дээр зарим эрх, үүргээ итгэмжлэл гарган Компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

#### ЕС. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

9.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, үйлдвэрлэл эрхэлсэн (ерөнхий инженер)орлогч захирал, санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, алба хэлтсийн дарга нар салбар төлөөлөгчийн газрын захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

9.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

9.3 Компанийн, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг, Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байгуулсан гэрээ, компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд Удирдах Зөвлөлтэй байгуулсан гэрээ, компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.4 Компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанийд учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

9.5 Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84,85 дугаар зүйлд зааснаар үүрэг, хариуцлага хүлээнэ.

АРАВ. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО



10.1 Компани нь хяналтын тогтолцоотой байх бөгөөд дараах бүтэцтэй байна.

10.1.1. Өмчлөгчийн хяналт

10.1.2. Дотоод хяналт

10.1.3. Хөндлөнгийн аудит

10.2. Өмчлөгчийн хяналтыг , Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлнэ.

10.3. Аудитын хороо 3 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг , Төлөөлөн Удирдах

Зөвлөл томилно

10.4. Аудитын хорооны дарга нь , Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн байна.

10.5. Компанийн аудитын хорооны ажиллах журмыг , Төлөөлөн Удирдах

Зөвлөл батална.

10.6. Аудитын хороо нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа энэхүү дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдлэнэ.

10.7 Компаний хөндлөнгийн аудитыг , Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс сонгосон мэргэшсэн аудитын байгууллагаар хийлгэнэ.

10.8 Хөндлөнгийн аудитын тайланг , Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

**АРВАН НЭГ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН  
АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ**


11.1. Их хэмжээний хэлцэл гэж хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хлэх бөгөөд түүнийг Компаний тухай хуулийн 87,88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан, боон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой компанийтай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг компаний тухай хуулийн 89, 91,92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.3 Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэхүү дүрмийн

13.1, 13.2,-т заасан хэлцлийн талаархи мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

**АРВАН ХОЁР. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ  
БҮРТГЭЛ, ТАЙЛАН**



12.1 Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна.

12.2 Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгөөр Төлөөлөн Удирдах Зөвлөл томилж, чөлөөлнө.

12.3 Компани нь хөндлөнгийн аудиторын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн Хувьцаа эзэмшигчид болон Бусад оролцогч талуудад танилцуулна.

12.4 Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацааг тухайн оны 1-р сарын 1-ний өдрөөс, (эсхүл эхний жил бол байгуулагдсан өдрөөс) дуусах хугацааг мөн оны 12-р сарын 31-ний өдрөөр тогтооно. ( эсхүл сүүлчийн санхүүгийн тайлант жил болон Компани нь татан буугдсан өдрийн байдлаар)

#### **АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

13.1. компанийн санхүүгийн тайланд дараах зүйлсийг тусгана.

13.1.1. Баланс:

13.1.2 Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан:

13.1.3. Мөнгөн гүйлгээний тайлан:

13.1.4. Өмчийн өөрлөлтийн тайлан:

13.1.5. Хуримтлагдсан ашгийн тайлан:

13.1.6. Тухайн тайлангийн хугацаанд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, терөл, үнийн дүнгийн хамт, удирдлагад олгосон цалин шагнал урамшуулал

13.1.7. Нэмэлт, тайлбар, тодруулга:

13.1.8. Санхүүгийн тайлангийн тодруулга:

13.1.9. Бусад

13.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ



## АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

14.1 компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй.

14.1.1. Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ:

14.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоот бичиг баримт:

14.1.3. Компанийн салбар болон төлөөлөгчдийн газрын дүрэм:

14.1.4. Нягтлан бодлох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг:

14.1.5. Хувьцаа эзэмшигчдийн хурал Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, Компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан гэрээ түүний биелэлтэд холбогдох баримт бичиг:

14.1.6 Хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулан хувьцаа эзэмшигчид тараасан баримт бичиг болон хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд оруулахаар ирүүлсэн санал

14.1.7. Аудитын дүгнэлт

14.1.8. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан:

14.1.9.Хувьцаа болон үнэт цаас гаргах журам: Анхан шатны болон нягтлан болох бүртгэлийн бичиг баримт:

14.1.10. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэrsийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо:

14.1.11. Бусад баримт бичгүүд:

14.2. Компани нь баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт хадгална.

14.3. Компани нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлтийг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатайгаар хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа архивд шилжүүлнэ.

14.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн Удирдах Зөвлөл, компаний хувьцаа болон үнэт цаас гаргах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн

гүйцэтгэнэ. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцна.

14.5. Компанийн талаархи мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлийн дагуу зохицуулна.

#### АРВАН ТАВ. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ

15.1. Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэлээр эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана.

15.2. Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

#### АРВАН ЗУРГАА. БУСАД ЗААЛТУУД

16.1. Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тоггоомжийн дагуу зохицуулна.

16.2. Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг компани дээр хадгална.



—oo—